

**ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2024 оны 07 дугаар сарын 09-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-9

1. Байнгын хорооны даргыг сонгох тухай 3-9

**Монгол Улсын Их Хурлын ес дэх удаагийн бүрэн эрхийн анхдугаар чуулганы
Инновац, цахим бодлогын байнгын хорооны
2024 оны 7 дугаар сарын 09-ний өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 15 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 19 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: А.Ганбаатар, Л.Гантөмөр, Ц.Мөнхбат, Б.Пунсалмаа.

Нэг.Байнгын хорооны даргыг сонгох тухай

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Инновац, цахим бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Бат-Эрдэнэ, референт П.Болорцэцэг нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Л.Мөнхбаатар, ХҮН намыг төлөөлж ХҮН намын Ерөнхий нарийн бичгийн дарга, Улсын Их Хурлын гишүүн П.Ганзориг нар Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргалыг Байнгын хорооны даргад нэр дэвшүүлсэн талаар танилцуулав.

Нэр дэвшигчээс болон танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабалын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Л.Мөнхбаатар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал, П.Сайнзориг, Д.Энхтүвшин, Ж.Чинбүрэн нар үг хэлэв.

Ж.Чинбүрэн: Инновац, цахим бодлогын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргалыг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	4
Бүгд:	11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Л.Соронзонболд нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр протоколд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 11 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, 81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 43 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 24 минут үргэлжилж, 15 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 73.3 хувийн ирцтэйгээр 13 цаг 43 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Ж.ЧИНБҮРЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 07 дугаар сарын 09-ний өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
13 цаг 19 минут.

ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Чинбүрэн: Манайх энэ технологи шинэчлэгдсэнтэй холбоотой Уянгаа гишүүний хуруу танигдахгүй байгаад байгаа учраас дахиж унтрааж сэргээх ёстой юм байна. Та бүхэн дахиад ирцдээ орно шүү.

Одоо системээ унтраагаад асаая. Эхлээгүй байгаа шүү. Хурал эхлээгүй. Нэг сэргээгээд тэгээд бүгдээрээ дахиад ирцдээ орох нь байна.

Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя.

Чинбаатарын Анар жагсаалтаар, Энхбаярын Батиугар 11 дүгээр тойрог, ирсэн. Амгаланбаатарын Ганбаатар жагсаалтаар, оролцоогүй байна. Лувсаннъямын Гантөмөр жагсаалт, ирээгүй байна. Батжаргалын Заяабал 2 дугаар тойрог, ирсэн байна. Жаргалсайханы Золжаргал 9 дүгээр тойрог, ирсэн байна. Цагаанхүүгийн Мөнхбат 12 дугаар тойрог, ирээгүй байна. Тогтмолын Мөнхсайхан 7 дугаар тойрог, ирсэн байна. Чинбатын Номин 11 дүгээр тойрог, ирсэн байна. Бадамдоржийн Пунсалмаа жагсаалтаар, ирээгүй байна. Пүрэвжавын Сайнзориг 11 дүгээр тойрог, ирсэн байна. Лхагвасүрэнгийн Соронзонболд 6 дугаар тойрог, ирсэн байна. Болдын Уянга жагсаалтаар, ирсэн байна. Саруулсайханы Цэнгүүн

жагсаалт, ирээгүй байна. Жигжидсүрэнгийн Чинбүрэн 8 дугаар тойрог, ирсэн байна. Хуралдаанд ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц бүрдсэн тул Инновац, цахим бодлогын байнгын хорооны 24 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Нэг асуудал байгаа. **Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудал.**

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? Өөр хэлэлцэх асуудал дээр?

Байхгүй байна.

Хэлэлцэх асуудал руугаа оръё. Хэлэлцэх асуудлыг эхлэхэд Монгол ардын намын бүлгийн дарга Мөнхбаатар дарга бүлгийн байр суурийг бас танилцуулж, үг хэлье. Мөнхбаатар даргын микрофоныг нээгээрэй.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны эрхэм гишүүдийн амрыг эрье. 2024 оны ээлжит сонгуулийн үр дүнд бий болсон Улсын Их Хурал бүтцээ байгуулж байна. Ингээд энэ бүтцээ байгуулахдаа Улсын Их Хуралд суудалтай намууд, тэр дотроо Ардчилсан нам, ХҮН намтай бодлогын түвшинд хамтран ажиллахаар зөвшилцсөн. Энэ агуулгаараа Засгийн газрын түвшинд ч тэр, Улсын Их Хурлын түвшинд ч тэр хамтран ажиллах нь зүйтэй гэж үзсэн байгаа.

Түүнээс гадна Улсын Их Хуралд авсан суудлын тоог бас харгалзан Улсны Их Хурлын бүтцийн байгууллагуудынхаа удирдлагыг томилох нь зүйтэй гэж бас зөвшилцсөн байна.

Тийм учраас энэ удаа, танайх чинь Инновац, цахим бодлогын байнгын хороо тийм ээ? Инновац, цахим бодлогын байнгын хороог ХҮН нам удирдлагыг нь

томилох энэ асуудлаар бас Монгол Ардын намын бүлэгтэй зөвшилцөж ойлголцсон гэдгийг бас та бүгдэд хэлье. Ингээд ХҮН намыг төлөөлж Ганзориг гишүүн танилцуулга хийе нэр дэвшигчийнхээ талаар.

Ж.Чинбүрэн: Монгол ардын намын байр суурийг та бүхэн сонслоо. Одоо ХҮН намын Ерөнхий нарийн бичгийн дарга Пүрэвжавын Ганзориг гишүүн үг хэлье. Пүрэвжавын Ганзориг гишүүний микрофоныг нээе.

П.Ганзориг: Байнгын хорооны нийт гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Инновац, цахим бодлогын байнгын хороонд нэр дэвшигч Улсын Их Хурлын гишүүн Жаргалсайханы Золжаргалын товч танилцуулгыг хийе.

Жаргалсайханы Золжаргал нь 1979 онд Хөвсгөл аймагт төрсөн. Боловсрол 1994-2004 онд Санкт-Петербургийн Уул уурхайн дээд сургуулийг инженерээр төгссөн.

2008-2010 онд Токиогийн Технологийн дээд сургуулийг бас инженерийн магистраар төгссөн. Орос, Англи хэлтэй.

Төгссөн хөтөлбөр курсүүд гэх юм бол 2005 онд Хятадын Нефтийн их сургууль, 2009 онд Токио дахь НҮБ-ын их сургууль, 2011 онд Австралийн Брисбан хотын “Мега-төслийн менежмент”-ээр төгссөн.

2016 онд Германы техник, технологийн тусалцааны байгууллага буюу “Жи Ай Зэт”-ийн Улаанбаатар дахь “Олборлох салбарын төслийн хэрэгжүүлэлт” иймэрхүү курс, хөтөлбөрүүдийг төгссөн.

Ажлын туршилагын хувьд 2004-2017 оны хооронд “Монголын Алт” компанид Инженер, технологийн судалгааны төвийн захирал, төслийн менежерээр тус тус ажилласан.

2017-18 он Даян дэлхийн ногоон хөгжлийн байгууллагад шинжээч, зөвлөх.

2018-19 онд И Би Ар Ди Улаанбаатар хотын Ногоон хөгжлийн хөтөлбөрийн төслийн зөвлөх.

2018-19 онд -Эрдэнэс Тавантолгой” ХХК-д зөвлөх.

2019 оноос Нүүрс ассоциацийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байгаа.

Мөн Түли, эрчим хүчний семинарыг санаачлагч, зохион байгуулагч 2016 оноос хойш, 2017 оноос хойш Үндэсний олон нийтийн телевизийн Монгол Инженер нэвтрүүлгийн зөвлөх, хөтөлгөч, мөн НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн төслийн хүрээнд тээврийн салбарын хүлэмжийн хийн ялгарлын тооцооллын автоматжуулах цахим платформыг бас хөгжүүлсэн. Гэр хорооллын барилгын хүлэмжийн хийн ялгарлын тооцооллын цахим систем бүтээх ажлыг ахалж ажилласан.

Инновац, технологийн мэдлэг түгээх чиглэлээр бас инженерийн шийдэл нэвтрүүлгийг хөтөлж байгаа ийм ажлын туршилагатай байна. Ингээд нийт Байнгын хорооны гишүүдийг Инновац, цахим бодлогын байнгын хорооны даргад нэр дэвшигч Улсын Их Хурлын гишүүн Жаргалсайханы Золжаргалыг дэмжиж өгөхийг хүсье. Баярлалаа.

Ж.Чинбүрэн: ХҮН намын дэвшүүлж байгаа нэр дэвшигчийг сонслоо.

Өөр Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх саналтай нэр дэвшигч байна уу?

Болно шүү дээ. Бүлгийн даргаас асуулт асууя гэж байна. Микрофон, бүлгийн дарга асуулт асууя гэж байна. Үг хэлэх гэж байна уу? Санал, юм асуух гэж байна уу? Асуулт асуух гэж байна уу?

Батжаргалын Заяабал гишүүний микрофоныг нээе.

Б.Заяабал: Байнгын хорооныхоо гишүүдэд энэ өдрийн өглөөний мэнд хүргэе. Би энэ шинэ гишүүн болоод ч тэр юм уу жосоохон төөрөгдөлтэй л яваад байгаа юм. Эвслийн Засгийн газар хамтарч Засгийн газрыг байгуулна гэдэг ийм нэр томъёо явж байна. Тэгэхлээр би энэ Засгийн газрынхаа хэмжээнд Ерөнхий сайд намын удирдах зөвлөл бага хурал дээр ч гэсэн танилцуулсан. Тэр дагуугаа Засгийн газрынхаа танхимыг хамтарсан хэлбэрээр явуулна гэдэг л ийм л ойлголттой байсан л даа. Тэгтэл өнөөдөр Байнгын хороодууд ингээд хамтарсан хэлбэрээр орж ирж байна. Энэ нь яг тэр Засгийн газрыг хамтрах гэдэг томъёолол чинь Улсын Их Хурлын Байнгын хороодоос ингээд хамтраад явах нь орж байгаа юу? Тэгээд намуудын байгуулсан энэ хамтарсан Засгийн газрын энэ хэлэлцээр гээд тэрийг бас гишүүдэд өгөх боломжтой юу гэсэн ийм л 2 асуулт асуух гэсэн юм.

Ж.Чинбүрэн: Мөнхбаатар даргын микрофоныг нээе. Мөнхбаатар даргын микрофон өгчихье. Гарчихсан юм уу, үгүй юү? Ирц байхгүй шууд микрофон нээх юм. Түрүүн нээсэн дээ.

Л.Мөнхбаатар: Заяабал гишүүний асуултад хариулъя. Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн үр дүнд парламентад суудалтай таван нам Улсын Их Хуралд орж ирсэн. Энэ дотроос Ардчилсан нам, ХҮН нам, Монгол Ардын нам гурав бол хамтарч ажиллах санамж бичигт бас гарын үсэг зурж, ажиллаж байна. Цаашидаа Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх түвшинд ч гэсэн хамтран ажиллахаар энэ асуудал явагдаж байна.

Ер нь Улсын Их Хурлын түвшинд ч гэсэн ард иргэдийн өгсөн санал, намуудын авсан суудлын дагуу энэхүү зохион байгуулалтын бүтэц дээрээ ч гэсэн хамтарч ойлголцож байх нь зүйтэй

гэж намын удирдлагууд хийгээд Улсын Их Хурлын удирдлагын зүгээс ингээж үзсэн байгаа юм. Авсан суудалд нь тохирсон хэмжээний бас энэ бүтцийн байгууллагууддаа бас хамтарч ажиллах нь зүйтэй гэж үзсэн.

Үүний дагуу Хүн намд Нийгмийн бодлогын байнгын хороо, Инновац, цахим бодлогын байнгын хороо хоёрыг удирдаж ажиллахаар тохирсон. Үүнийхээ дагуу өнөөдөр энэ томилгоо хийгдэж байгаа гэдгийг хэлье.

Ж.Чинбүрэн: Заяабал гишүүн асуулт хангалттай, тодруулах юм уу? Заяабал гишүүний микрофоныг нээе. 1 минут.

Б.Заяабал: Миний асуусан хоёр дахь асуулт нь хамтарсан тэр гэрээ байгуулсан гэрээг гишүүдэд өгч болох юм болов уу гэдэг ийм асуулт асуусан. Тэр дээр хариулт өгвөл.

Ж.Чинбүрэн: Мөнхбаатар даргын микрофоныг нээе.

Л.Мөнхбаатар: Энэ талаарх мэдээллээ Монгол Ардын намын Удирдах зөвлөлөөс та авч болно. Энд Удирдах зөвлөлд та бүхэн хандаж болно. Монгол Ардын намын гишүүнийхээ хувьд хандаад авч болно.

Ж.Чинбүрэн: Асуулт асууж дууслаа. Өөр нэр дэвшүүлэх санал байхгүй гэж үзээд Байнгын хорооны даргад нэр дэвшигчээс асуух асуулттай гишүүдийн нэрсийг авъя. Асуулт асуух гишүүд байна уу?

Байхгүй байна.

Үг хэлэх гишүүд байна уу? Үг хэлэх гишүүд байвал санал авъя, нэрс авъя. Юун дээрээ дар, тэр голынхоо юун дээр.

Заяабал. Нэг л хүний нэр орж ирээд байна даа. Бүртгэлтэй байгаа юу? Хэнийг энэ чинь манай Байнгын хорооны

гишүүн биш юм уу? Заяабал гишүүн үг хэлж байя.

Б.Заяабал: Тэгэхлээр Байнгын хорооны даргад нэр дэвшсэн Золжаргал гишүүнд бас баяр хүргэе. Миний асуух гээд байгаа санал, хэлэх гээд байгаа санал бол энэ төрийн үйл ажиллагааг ил тод, олон нийтэд нээлттэй болгох үүднээс энэ Цахим бодлого, инновацын байнгын хороо онцгой манлайлж ажиллах ёстой гэж ингэж үзэж байгаа. Төрийн бүх байгууллагууд өнөөдөр нууц биш ил тод байдаг, төрийн үйлчилгээ бол олон нийтэд нээлттэй, ил тод байх ёстой. Энэ агуулгаараа бол төрийн бүх үйл ажиллагааг нь цахимжуулах, дээр ил тод, нээлттэй болгох дээр бас онцгой анхаарч ажиллана гэж ингэж бодож байна.

Хоёрдугаарт, миний хэлэх гэж байгаа зүйл бол энэ олборлох үйлдвэрийн ил тод байдлын санаачилгын тухай, санаачлахад Монгол Улс 2011 онд нэгдсэн. Энэ хуулийн төсөл бас боловсруулагдаад Олборлох үйлдвэрийн ил тод байдлын санаачилгын тухай хууль гэж боловсруулахаар хуулийн төсөл нь явж байсан. Тэн дээр би бас манлайлж энэ хуулийн төслийг үргэлжлүүлж, боловсруулж бас өргөн барина гэж ингэж бодож байгаа юм.

Энэ дээр бас Инновац, цахим бодлогын байнгын хороо бас манлайлж ажиллана аа гэж бодож байна. Ялангуяа Золжаргал гишүүний хувьд бол өөрөө өмнө нь энэ бол уурхайн салбартай нэлээн холбоотой ажиллаж ирсэн. Өнөөдөр манай Монгол Улсын уул уурхайн ашигт малтмалыг ашигладаг эдгээр аж ахуйн нэгжүүдийн дата мэдээлэл маш их зөрүүтэй байдаг. Маш олон байгууллагууд хариуцдаг. Уулын ажлын төлөвлөгөө гэхэд Ашигт малтмалын газар, тэгээд нөхөн сэргээлт энээ тэрээ асуудлууд нь Байгаль орчны яаман дээр, тэгээд татвар, гааль нь болохоор зэрэг бас ингээд мэдээлэл байдаггүй. Хэчнээн куб метр шороог олборлоод, хэдий хэмжээний баялгийг

олборлосон бэ гэдэг мэдээллийг одоо энэ төрийн байгууллагууд хоорондоо бас мэдэж чаддаггүй л дээ.

Тэгэхлээр энэ Олборлох үйлдвэрийн ил тод байдлын тухай хуулийг бол санаачилж гаргах дээр бас дэмжиж хамтарч ажиллахыг бас танд уриалж бас энэ саналыг гаргаж байгаа юм.

Ер нь монголчууд бол энэ ашиглаж байгаа Монгол Улсын Үндсэн хуулийн 6.2 дээр ч байгаа “газрын доорх баялаг бол ард түмний мэдэлд байх ёстой. Ашигтай хэлбэрээр ашиглах хэрэгтэй” гэсэн үндсэн концепц байгаа. Тэгээд энэ олборлох үйлдвэрийн ил тодын санаачилгын хүрээнд энэ боловсруулж байгаа уулын ажлын төлөвлөгөө, олборлож байгаа хэмжээ, гаргаж байгаа хэмжээ, бүх зүйл нь төрийн хяналт дээр явж ярих ёстой л доо. Өнөөдөр бол энэ байхгүй байгаа. Зүгээр алтны компаниудын жишээ аваад ярихад Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр батлагдсан нөөцийг нь аваад үзэхэд 1 куб метрт байгаа алтных нь хэмжээг аваад үзэхэд олборлосон куб метрийнх нь ашигласан тэр шороог нь аваад үзэхэд яг Монголбанкинд тушаасан алтны хэмжээ нь зөрдөг. Өнөөдөр Монгол Улс 20-оод тонн алтыг Монголбанкинд тушаадаг боловчиг 10 тонныг нь хувь хүнээр, 10 тонныг нь аж ахуйн нэгжээр тушааж байх жишээтэй гэх мэтчилэн зүгээр ганцхан металлын хувьд бол ийм байгаад байгаа юм.

Тэгэхлээр энэ бүх асуудлыг бид нар цэгцэлж, янзлах, олон нийтэд ил тод, нээлттэй болгох чиглэлээр бас энэ манай Байнгын хороо бас онцгой анхаарч ажиллах байх.

Ялангуяа Байнгын хорооны шинэхэн даргаар томилогдож байгаа юм байна. Томилогдох нэр дэвшиж орж ирсэн Золжаргал гишүүнийг бас энэ дээр анхаарч ажиллахыг хүсэж, санал хэлж байгаа юм. Баярлалаа.

Ж.Чинбүрэн: Ирцэд
Саруулсайханы Цэнгүүн гишүүн
жагсаалтаар ирсэн байна.

Одоо хэн үг хэлэх байлаа?
Сайнзориг гишүүн. Сайнзориг гишүүний
микрофоныг нээе.

П.Сайнзориг: Би товчхон. Энэ
Байнгын хорооны бас уг нь чиг үүрэг их
чухал байгаа. Авлигатай тэмцэх бас
хамгийн зөв нэг арга механизм бол уг нь
энэ цахимжуулалтын бодлого байгаа.
Өнөөдөр И-Монголиагийн бас нэлээн
үйлчилгээ иргэдэд нэлээн хүртээмжтэй
байгаа. Энэний аюулгүй байдал, хүлээн
зөвшөөрөгдөх байдлыг бас нэмэгдүүлэх
чиглэлээр бас хаврын чуулганаар
нэлээдгүй олон хуулийн бас давхардал,
хийдлийг арилгах энэ арга хэмжээнүүд
авсан.

Ер нь цаашидаа энэ шүүх эрх мэдэл
буюу шүүн таслах ажиллагаан дахь яг
энэ инновац, цахимжилтын бодлого бол
нэлээн хоцрогдолтой байгаа. Бид хэд энэ
цахимжилтын бодлогыг зөвхөн Засгийн
газрын түвшиндээ ярьж байгаад энэний
хүлээн зөвшөөрөгдөх байдал одоо банк
санхүүгийн салбар, эргээд энэ шүүх эрх
мэдлийн засаглалын хоорондын уялдаа
жоохон хангагдахгүй талууд байгаа.
Тэндээс гарсан бичиг баримтыг шүүх
дээр нотлох баримтаар үнэлдэггүй ч
гэдэг юм уу.

Тэгэхээр бид нар энэ шүүн таслах
ажиллагаа дээрх энэ цахимжилт,
инновацын бодлогыг яг энэ шүүх эрх
мэдлийн байгууллагуудын бас үйл
ажиллагаатай уялдуулах асуудал байна.
Шүүхийн процессыг бас цахимжуулах,
зайнаас шүүх хуралдаанд оролцох. Эргээд
зарим бүр оронд чинь, манай БНХАУ
буюу урд хөршид чинь домэйн нэртэй
холбоотой болон одоо яг энэ цахим
орчинд үүссэн оюуны өмчийн
бүтээмжийн маргааныг цахим орчинд
шүүж байгаа шүү дээ. Робот шүүх
шүүж байгаа гэх зэрэг. Бид нарт бас яах
вэ энэ ажил бол болчихлоо гэдэг утгаар
нь биш бас илүү их шинэлэг байдлаар

анхаарч ажиллах зайлиггүй шаардлага
байгаа юм.

Тэгээд цахим хавтаст хэргийн
асуудлууд байгаа. Эргээд энэ архивын үйл
ажиллагааг бас энэ цахимжуулалтаар
дэмжих ажил байгаа. Бүх бичиг
баримтууд эцсийн дүндээ очиж архив
дээр зогсдог. Архивын үйл ажиллагааг
цахимжуулалт дөнгөж 20 хувьтай
байгаа улсын хэмжээнд.

Тэгэхээр энэ ажлуудыг бас нэг
эрчимжүүлэх ажлаар энэ манай Байнгын
хороо бас шинээр томилогдож байгаа
дарга бас анхаарч ажиллана биз ээ гэж
би бодож байна. Тэгээд цахим орчин дахь
хүний эрхийн асуудал, тэр дундаа
хүүхдийн эрхийн асуудал, эргээд энэ
аюулгүй байдалтай холбоотой энэ
зүйлүүд дээр зайлиггүй бас хэдийгээр
цахим 5 багц хуулийг батлуулсан. Миний
бие өөрөө эдгээр 5 багц хуулийг
боловсруулсан хүн байгаа. Мэдээж одоо
бас илүү сайжруулах асуудлууд байгаа
гэдэг зүйлийг би бас анхааруулж хэлээд
энэ чиглэлдээ бас анхаараарай. Зөвхөн
бас энэ Засгийн газрынхаа гэдэг юм уу
Засгийн газрын үйл ажиллагааны хэсэг
дээр биш, шүүн таслах буюу шүүх эрх
мэдлийн байгууллагуудын үйл ажиллагааг
цахимжуулах чиглэл рүү нэлээн анхааръя.
Энэ дээр бас Улсын Их Хурлын Тамгын
газар нэлээдгүй манлайлалтай оролцдог.
Тэгэхээр энэ үйл ажиллагаануудыг
уялдуулж бас хаа хаанаа төрийн үйл
ажиллагаанаас гарч байгаа энэ цахим
бичиг баримтууд хүлээн зөвшөөрөгддөг,
нотлох баримтаар үнэлэгддэг энэ чиглэл
рүүгээ явах талаас нь бас анхаарах. Энэ
цахим гарын үсгийн хэрэглээний ач
холбогдлыг бид нар бас ойлгуулмаар
байна. Ингэж байж цахим гэрээнүүд
одоо явагдана.

Эргээд энд олгож байгаа цахим
гарын үсэг манай хилийг даваад бусад
оронд зөвшөөрөгдөх, эргээд юу гэдэг юм
бусад оронд олгосон цахим гарын үсгийг
энд хүлээн зөвшөөрөх энэ тэр гээд
шийдлээ хүлээсэн бас техникийн ажлууд
бий. Энэ ажлууд нь Цахим хөгжил,

харилцаа холбооны яаман дээр бас тодорхой нэг программ хангамж, хатуу дэд бүтцийн хувьд билүү зөөлөн дэд бүтцийн хувьд билүү нэг гагцхисан юмнууд байгаа.

Тэгэхээр уг асуудлуудыг анхаарч бас шийдвэрлэх талд нь бас бодолцоорой гэдэг зүйлийг бас хэлмээр байна. Баярлалаа.

Ж.Чинбүрэн: Пүрэвжавын Сайнзориг гишүүн үг хэллээ. Санал хураалтад оролцохгүйгээр үг хэлэх эрхтэйгээр гишүүд Байнгын хороонд оролцдог. Энхтүвшин гишүүний микрофоныг нээж үг хэлүүлье. Энхтүвшин гишүүний микрофон. Тэрийг нь хэлээрэй. Битгий дар.

Д.Энхтүвшин: Би нэг л санал хэлэх гэсэн юм. Монгол ардын намын мөрийн хөтөлбөрт энэ инновац, технологитой холбоотой нэг чухал заалт орсон байгаа. Тэгээд энэ заалт маань бас Засгийн газрын мөрийн хөтөлбөрт орно байх гэж бодож байна. Тэгэхээр энэ Байнгын хорооноос бас нэг заалт дээр, энэ заалт дээр нэлээн анхаарч ажиллаасай гэж хүсэж байгаа.

Энэ юу вэ гэхээр Үндэсний баялгийн сангийн 1-ээс доошгүй хувийг инновац, технологийн салбарт зориулж, эдийн засгийн салбаруудын бүтээмж, экспортын хэмжээг нэмэгдүүлнэ гэж заасан байгаа. Энэ заалтыг бас Засгийн газраас яг энэ баялгийн сангийн энэ 1-ээс доошгүй хувийг энэ салбарт инновац, технологид энэ зарцуулах чиглэлд нь бас нэлээн шахаж ажиллаарай гэж хэлмээр санагдаж байгаа.

Яагаад вэ гэхээр ер нь бол эдийн засгийн өсөлтийг аваад үзэхээр бүтээмжийн өсөлт хийхгүй бол бас эдийн засгийн өсөлт хийхэд нэлээн хэцүү байгаа. Экспортын өсөлт хийхгүй бол эдийн засгийн өсөлт бас хийхэд хэцүү байгаа. Тэгэхээр яг энэ 2 дээр чухал ач холбогдолтой зүйл бол яг энэ инновац, технологитой холбоотой заалт байгаа.

Тэгэхээр энэнтэй холбоотой ийм тодорхой амлалтууд байгаа учраас энэ заалтуудыг нь хэрэгжүүлэлт дээр нэлээн шахаж ажиллаарай гэж хэлмээр байна. Тэгээд ер нь бол энэ инновацтай холбоотой бусад улсуудын жишигийг харахад бол инновацтай холбоотой том хөрөнгө оруулалтыг ер нь улсын төсвийн санхүүжилтээр, улсын санхүүжилтээр хийдэг жишигүүд олон байдаг.

Жишээлбэл, хувийн компаниудын олон шинэ бүтээгдэхүүнүүдийн гол гол үндсэн инновац ноу хаунууд нь төсвийн санхүүжилтээр хийгдчихсэн ийм зүйлүүд их байдаг. Тэгэхээр энэ хувийн болон энэ төрийн энэ салбаруудад энэ инновац, технологийн салбарын мөнгийг зөв хуваарилах, энийг үр дүнтэй ашиглах талаар бас шахаж ажиллахыг Байнгын хорооны нийт гишүүд болон Байнгын хорооны томилогдох гэж байгаа шинэ удирдлагад бас хэлэхийг хүссэн юм. Баярлалаа.

Ж.Чинбүрэн: Баярлалаа. Би Жаргалсайханы Золжаргал гишүүнд бас хандаж бас үг хэлье.

Би бас өнгөрсөн хугацаанд 20-24 оны 8 дахь удаагийн парламент анх удаагаа Инновац, цахим бодлогын байнгын хороо байгуулан тэгээд яамтай болсон, бодлогын яамтай болсон. Энэнтэй холбоотойгоор бол энэ Байнгын хороонд ажиллаж Батиугар гишүүн бид 2 одоо яг төлөөлөн энд сууж байна. Олон хууль, эрх зүйн орчнуудыг шинэчилсэн.

Энэ дотор бол ялангуяа энэ старт-ап компаниуд, үйлдвэрлэл цахим орчинд үйлдвэрлэлийг дэмжих, энэ том бодлогыг хүртэл дэмжих хууль, эрх зүйн орчныг бүрдүүлсэн байгаа. Тэгэхлээр Их Хурлын гишүүд бид нарын бас нэг том чухал үүрэг бол хууль санаачлахаас гадна хуулийн хэрэгжилтэд бас хяналт тавих ажлын хэсгүүд гаргаж ажиллах. Тэр хуулийн хэрэгжилт ямар шатандаа явж байгаа гэдгийг Засгийн газрыг шахаж ажиллах бүрэн эрх бидэнд байгаа.

Нөгөө талаасаа бас Байнгын хорооны гишүүддээ бас хэлэхэд бид өдөр тутам байнгын үйл ажиллагаатай байнгын Их Хурлын Байнгын хорооны үйл ажиллагаанд идэвхтэй, санаачилгатай, өдөр тутам Байнгын хорооны даргатайгаа уулзаж учирч шаардах зүйлээ шаардах бүрэн эрх бидэнд байгаа.

Хоёр дахь хэлэх гэсэн зүйл бол манай эрүүл мэндийн салбарт бол цахимжилтын асуудал одоо хамгийн хоцрогдсон, хамгийн доройтсон салбар байгаа. Өнгөрсөн хугацаанд Дэлхийн банкны 19 сая доллароор эрүүл мэндийн салбарын цахимжилтаа хийж чадаагүй унасан. Зарим нэг улсууд нь авлигал, хээл хахуулийн асуудалд орчихсон байгаа. Саяхан бас нэг сайхан мэдээ дуулахад тэр тендер аваад ялсан Солонгосын компаниас 1.2 сая доллароо буцааж авсан сурагтай байна. Тийм, Дэлхийн Банк. Энэ чинь нэг ёсондоо Монгол Улс өөрөө нөгөө өөрөө өрөнд орчхоод байсан байхгүй юу. Юмаа хийгээгүй байтал.

Тэгэхлээр энэ эрүүл мэндийн салбарын цахимжилтын асуудал дээр бид бас онцгой анхаарах ёстой. Тэгээд энэ асуудлуудыг бүгдийг нь анхаарч, Байнгын хороон дарга бол Байнгын хороодын гишүүдийн оролцоог жигд хамруулах нь бас таны гол үүрэг болох юм.

Түүнээс хэн нэгэнд нь давуу эрх, эс үгүй бол аль нэг намаар нь ялгаварлан гадуурхвал энэ Байнгын хорооны даргын ажил биш шүү гэдгийг анхааруулж, сануулж хэлье.

Ингээд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Улсын Их Хурлын гишүүн Жаргалсайхан овогтой Золжаргалыг Инновац, цахим бодлогын байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураая.

Болж байна, болж байна тийм

Нийт 63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хэний юу яасан гэнэ ээ? Цэнгүүн гишүүн дэмжсэн учраас протокол тэмдэглэнэ биз. Ингээд олонхын саналаар Соронзонболд бас дэмжсэн юм байна. Энийг 2 хүний санал ороогүй учраас энэ протокол тэмдэглэхчхэнэ биз.

Ингээд Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Лхагвасүрэнгийн Соронзонболд та танилцуулна уу. Анх удаагаа бас Их Хурлын юун дээр очиж Байнгын хорооны дүгнэлтийг униших нь байна шүү та.

Хэлэлцэх асуудал дуусчихсан тул өнөөдрийн Байнгын хорооны хуралдааныг хаасныг мэдэгдье.

Байнгын хорооны гишүүддээ бас анхны хурал. Та бүхэн Монголын өв соёл болсон сайхан наадмаа, Монголын дархлаа болсон Монголын наадмаа дэнж хотойтол дэлгэр сайхан наадацгаагаарай гэж ерөөе. Ингээд хурал дууслаа.

13.43 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР

